

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/45/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн
Захирал Ц.Жигдэн
Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.2 Албан шаардлага	14
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ОХУ	Оросын Холбооны улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН НЭГДСЭН
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Н.УУГАНЧИМЭГ ТАНАА

2026.04.03 № 06/339
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 17,388.0 мянган төгрөгөөс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Эрчим хүчний яамны захиалгаар төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгийн сумдын дөрвөн байршилд хөрсний гүнийн дулааны насос суурилуулах түлхүүр гардуулах нөхцөлтэй олон улсын нээлттэй тендер шалгаруулалтад “Нар Энержи селикон метал” ХХК, ОХУ-ын Броск ХХК-ийн түншлэл шалгарч 2021-2023 онд гэрээ байгуулсан боловч тухайн ажлуудын гэрээний хугацаа дууссан, төслийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 24.5 хувь, барилга угсралтын ажлын гүйцэтгэл дунджаар 56.6 хувь, санхүүжилт 62.3 хувийн гүйцэтгэлтэй, улсын комиссын дүгнэлт баталгаажаагүй байна. Тухайлбал:

- Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар сургуулийн барилгын дулаан хангамжид 110.0 кВт чадалтай дулааны насос, 25.0 кВт чадалтай нарны коллектор суурилуулах ажлын гүйцэтгэлийг 2023 онд ашиглалтад өгсөн боловч

дулааны техник алдагдлын тайлангаар суурилагдсан хүчин чадал нь нийт барилгыг халаахад хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан;

- Баянхонгор аймгийн Өлзийт сумын ахлах сургуулийн барилгын дулаан хангамжид 106.2 кВт суурилуулах ажлын хүрээнд Броск II -500 маркийн насосын оронд Хятад улсын CGS-52 маркийн 56.0 кВт-ын насос суурилуулсан, Эрчим хүчний яамнаас насос солих талаар албан ёсны зөвшөөрөл аваагүй;
- Говь-Алтай аймгийн Алтай сумын эмнэлэг, захиргааны барилгын дулаан хангамжид 95.0 кВт хөрсний гүний дулааны насосын систем суурилуулах ажлын хүрээнд батлагдсан ажлын зургийн дагуу 100 метрийн гүнтэй өрөмдөх ажлыг 30 метрийн 4 цооног болон бусад цооногийг 2-5 метрийн гүнтэй өрөмдөж ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, мөн 15,825.00 ам.доллар буюу 56,284.1 мянган төгрөгийн /2025.12.31-ны өдрийн Монгол банкны ханш 3,556.66 төгрөг/ үнэтэй 53.1 кВт хүчин чадалтай 1 ширхэг насосыг дутаасан талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн албан томилолтын ажлын тайланд тусгасан;
- Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар сургуулийн барилгын дулаан хангамжид 244.0 кВт хөрсний дулаан насосын систем суурилуулах ажлын хүрээнд 75.0 кВт чадалтай нарны коллектор суурилуулах байтал 36.0 кВт чадалтай коллектор суурилуулсан, зөрүүг тооцоогүй, мөн 51,056.00 ам.доллар буюу 181,588.8 мянган төгрөгийн /2025.12.31-ны өдрийн Монгол банкны ханш 3,556.66 төгрөг/ үнэтэй 81.5 кВт чадалтай 2 ширхэг насосыг дутаасан талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн албан томилолтын ажлын тайланд тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, Засгийн газрын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана”, Гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр бүлэг “Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага” хэсгийн 9.1-д “Гүйцэтгэгч нь гэрээний дагуу төлөвлөсөн ажлыг бүрэн хийж дуусгах” гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 10 МВт цахилгаан станцыг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлт гарч, тайлант онд 23,211,100.0 кВт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 22,895,180 кВт /цаг цахилгаан эрчим хүч нийлүүлсэн байна. Тайлант онд ашиглалтад орсон 4 нарны цахилгаан станц нийт 93.32 сая кВт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн байна.

Аудитын гол асуудал

Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 174 дүгээр тушаалаар “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”-ыг баталж, холбогдох бүтэц, орон тоог батлан **46 төсөл хэрэгжүүлэх нэгжийг 17 нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлсэн байна.**

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

Код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	93,016,516,786.55	2,116,759,205.95
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	2,215,722,308.46	2,111,408,105.95
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,215,722,308.46	2,111,408,105.95
31211	Төрийн сангийн харилцах	97,458.02	58,420,941.50
31221	Төрийн сангийн харилцах Ам.доллар	2,215,624,850.44	2,052,987,164.45
34	УРЬДЧИЛГАА	3,950,500.00	3,950,500.00
34600	Урьдчилж гарсан зардал	3,950,500.00	3,950,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	90,796,843,978.09	1,400,600.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	90,795,443,378.09	-
35470	Бусад хангамжийн материал	1,400,600.00	1,400,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	65,848,175.18	93,768,786,950.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	65,848,175.18	35,107,312.08
39200	Биет хөрөнгө	42,933,135.84	21,067,572.95
39203	Авто тээврийн хэрэгсэл	63,900,000.00	63,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(56,800,000.00)	(63,900,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	91,057,927.18	91,057,927.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(62,731,400.93)	(75,212,121.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,743,376.00	18,743,376.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,236,766.41)	(13,521,608.79)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,270,000.00	2,270,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,270,000.00)	(2,270,000.00)
39300	Биет бус хөрөнгө	22,915,039.34	14,039,739.13
39301	Програм хангамж	49,096,197.00	49,096,197.00
39302	Хасагдуулга	(26,181,157.66)	(35,056,457.87)
39400	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	93,733,679,637.97
39403	Дуусаагүй барилга, байгууламж	-	93,733,679,637.97
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	93,082,364,961.73	95,885,546,156.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	93,082,364,961.73	95,885,546,156.00
51	Засгийн газрын хувь оролцоо	93,082,364,961.73	95,885,546,156.00
51200	Хуримтлагдсан үр дүн	93,082,364,961.73	95,885,546,156.00
51210	Өмнөх үеийн үр дүн	67,033,481,105.87	93,082,364,961.73
51220	Тайлант үеийн үр дүн	26,048,883,855.86	2,803,181,194.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	93,082,364,961.73	95,885,546,156.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	28,107,982,282.22	3,870,354,593.84
122002	Хандив тусламжийн орлого /гадаад/	28,029,263,279.03	3,765,927,892.28
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	78,719,003.19	-
120009	Бусад орлого	-	89,845,760.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	14,580,940.85
131001	Хандив тусламж /гадаад/	-	14,580,940.85
2	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	715,673,063.28	865,939,050.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	715,673,063.28	865,939,050.30

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	426,594,545.46	511,740,000.00
210101	Үндсэн цалин	426,594,545.46	511,740,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,324,318.19	63,967,500.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	53,324,318.19	63,967,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,894,113.00	61,894,113.00
210301	Байрны түрээс	61,894,113.00	61,894,113.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,827,973.97	7,451,381.58
210401	Бичиг хэргийн материал	2,064,920.00	962,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,700,000.00	3,600,000.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	3,063,053.97	2,889,181.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,480,000.00
210604	Урсгал засвар	-	1,480,000.00
2107	Томилолт, зочны зардал	83,767,200.00	96,180,000.00
210702	Дотоод томилолтын зардал	83,767,200.00	96,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	44,464,418.41	43,438,501.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,800,494.25	79,787,554.10
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	-	49,046,691.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,800,494.25	30,740,863.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	27,392,309,218.94	3,004,415,543.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	3,434,588.99	92,025,363.39
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,434,588.99	92,025,363.39
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,346,859,952.07	293,259,712.66
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	6,262,646.34	84,041.75
232001	Эргэж төлөгдөх зээл	1,340,597,305.73	293,175,670.91
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(1,343,425,363.08)	(201,234,349.27)
7	НИЙТ ҮР ДҮН	26,048,883,855.86	2,803,181,194.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,115,800,312.40	1,258,073,778.08
122002	Хандив тусламжийн орлого /гадаад/	1,115,800,312.40	1,168,228,017.37
120009	Бусад орлого	-	89,845,760.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,115,800,312.40	1,258,073,778.08
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,236,504,302.77	326,221,011.12
22	Хөрөнгийн зардал	1,236,504,302.77	326,221,011.12
220001	Барилга байгууламж	1,232,984,402.77	326,221,011.12
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,519,900.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,236,504,302.77)	(326,221,011.12)
7	САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	92,025,363.39
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	92,025,363.39
23	ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,082,718,607.80	1,128,108,291.11
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	1,082,718,607.80	1,128,108,291.11
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	2,828,057.35	84,041.75

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,828,057.35	84,041.75
8	САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,085,546,665.15)	(1,036,166,969.47)
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,206,250,655.52)	(104,314,202.51)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,421,972,963.98	2,215,722,308.46
100	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,215,722,308.46	2,111,408,105.95

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	67,033,481,105.87	67,033,481,105.87
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,048,883,855.86	26,048,883,855.86
Тайлант үеийн үр дүн	93,082,364,961.73	93,082,364,961.73
2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	93,082,364,961.73	93,082,364,961.73
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,082,364,961.73	93,082,364,961.73
Тайлант үеийн үр дүн	2,803,181,194.27	2,803,181,194.27
2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	95,885,546,156.00	95,885,546,156.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,554,000,000.00	4,017,563,426.99	536,436,573.01	88.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	850,000,000.00	340,801,951.97	509,198,048.03	40.1
220001	Барилга байгууламж	850,000,000.00	340,801,951.97	509,198,048.03	40.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,704,000,000.00	3,676,761,475.02	27,238,524.98	99.3
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	3,704,000,000.00	3,676,761,475.02	27,238,524.98	99.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,554,000,000.00	4,017,563,426.99	536,436,573.01	88.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,704,000,000.00	3,676,761,475.02	27,238,524.98	99.3
	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,704,000,000.00	3,676,761,475.02	27,238,524.98	99.3
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	850,000,000.00	340,801,951.97	509,198,048.03	40.1
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	850,000,000.00	340,801,951.97	509,198,048.03	40.1
	Төсвийн гүйцэтгэлийн тохируулга		104,314,202.51		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,215,722,308.46		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,111,408,105.95		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12	8	4	
620001	Удирдах ажилтан	1	1	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	11	7	4	
620003	Үйлчлэх ажилтан	0	0	0	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний үйл ажиллагаа

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийг АХБ, Уур амьсгалын стратегийн сан, Япон улсын хамтарсан зээлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх зээлийн болон буцалтгүй тусламжийн гэрээг Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан байна.

Гэрээнд заасны дагуу төслийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр байна. Үүнд:

- Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн 40.0 сая ам доллар;
- Уур амьсгалын стратегийн сангийн буцалтгүй тусламжийн 14.6 сая ам доллар;
- Япон улсын хамтарсан зээлийн буцалтгүй тусламжаар 6.0 сая ам доллар.

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл нь Монгол Улсын алслагдмал болон буурай хөгжилтэй бүс нутгуудад хуваарилагдсан сэргээгдэх эрчим хүчний системүүдийг өргөжүүлэх, зорилтот газруудад сэргээгдэх эрчим хүчийг бий болгох хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төслийг удирдах, цахилгаан шугам сүлжээг хянах, орон нутгийн цахилгаан түгээх компаниудын чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

Тус төсөл 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2027 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжинэ.

Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, АХБ-ны “Худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу төслийн үйл ажиллагаа болон худалдан авах ажиллагааг зохицуулдаг байна.

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хэрэгжүүлэгч байгууллага нь Эрчим хүчний яам, төсөл хэрэгжиж байгаа газар нь Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгууд байна.

3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 30 дугаар тушаалаар тус төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, төслийн хүрээнд хийх ажлын явц болон шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тухай бүр авч хэлэлцэн шийдвэрлэх чиг үүрэг бүхий Төслийн удирдах хороог байгуулсан байна.

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл нь Эрчим хүчний тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль дүрэм, журмыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 174 дүгээр тушаалаар баталсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төсөл нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч, Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 21 дүгээр бүлэг Гадаад зээл, тусламжийн бүртгэл, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрддөг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,803,181.1 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,215,722.3	2,111,408.1	(104,314.2)
Урьдчилгаа	3,950.5	3,950.5	-
Бараа материал	90,796,844.0	1,400.6	(90,795,443.4)
Үндсэн хөрөнгө	65,848.2	35,107.3	(30,740.9)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	93,733,679.6	93,733,679.6
Нийт хөрөнгө	93,082,365.0	95,885,546.1	2,803,181.1
Хуримтлагдсан үр дүн	93,082,365.0	95,885,546.1	2,803,181.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	93,082,365.0	95,885,546.1	2,803,181.1

Дээрх хүснэгтээс харахад, бараа материалын данс 90,795,443.4 мянган төгрөгөөр буурсан нь төслөөс хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтын өмнөх оны хуримтлагдсан үлдэгдлийг тайлант онд бусад эргэлтийн бус хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант хугацаанд бусад эргэлтийн бус хөрөнгө данс 93,733,679.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс 90,795,443.4 мянган төгрөг нь өмнөх оны хуримтлагдсан үлдэгдлийг бараа материалаас шилжүүлсэн, 2,938,236.2 мянган төгрөг нь тайлант онд Завхан хотын Улиастай сумын 5 мВт-ын нарны цахилгаан станцын гэрээт ажлын төлбөр 2,764,345.1 мянган төгрөг, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 мВт-ын нарны цахилгаан станцын гэрээт ажлын төлбөр 173,891.1 мянган төгрөгийг тус тус нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээл тусламжийн 4,554,000.0 мянган төгрөгөөр бүрдүүлж урсгал зардалд 3,704,000.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 850,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулахаар батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр 4,017,563.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгө оруулалтын зардалд 340,801.9 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээний зардалд 293,175.7 мянган төгрөг, гадаадын төслийн зээлээр санхүүжих 2,597,434.3 мянган төгрөг, төслийн нэгжийн зардалд 786,151.5 мянган төгрөг тус тус зарцуулж 88.2 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр	4,554,000.0	4,017,563.4	536,436.6	88.2
1.1	80104- Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил	3,704,000.0	3,676,761.5	27,238.5	99.3
1.2	80105- Гадаад тусламжаар хэрэгжүүлэх ажил	850,000.0	340,801.9	509,198.1	40.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 6 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт хувиар	Зарцуулах төсөв	Зарцуулсан
70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл						
80104 Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил						
1	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 мВт нарны цахилгаан станц	2022-2023	Ашиглалтад оруулах	100.0	176,000.0	173,891.1

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	Завхан аймгийн Алдархаан сумын 5 МВт нарны цахилгаан станц, Улиастай сумын цэнэг хураагуурын хамт	2021-2022	Ашиглалтад оруулах	100.0	2,430,000.0	2,423,543.2
3	Зөвлөх үйлчилгээ	2024-2025	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх	100.0	120,600.0	120,524.4
		2024-2025	ТЭЗҮ боловсруулах	100.0	113,400.0	113,374.9
		2022-2027	Техникийн комисс, Улсын комисс ажиллуулах	80.0	60,000.0	59,276.4
4	Төслийн удирдлага	2019-2027	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа		804,000.0	786,151.5
Дүн					3,704,000.0	3,676,761.5
80105 Гадаадын тусламжаар хэрэгжүүлэх ажил						
5	Баянхонгор аймгийн Өлзийт сумын ахлах сургуулийн барилгад хөрсний дулааны насос суурилуулах	2023-2025	Ашиглалтад оруулах	56.0	480,000.0	-
6	Завхан аймгийн Алдархаан сумын 5 МВт нарны цахилгаан станц, Улиастай сумын цэнэг хураагуурын хамт суурилуулах	2021-2022	Ашиглалтад оруулах	100.0	370,000.0	340,802.0
Дүн					850,000.0	340,802.0
Нийт дүн					4,554,000.0	4,017,563.4

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ахлах сургуулийн барилгын дулаан хангамжид 106.2 кВт-ын хөрсний дулаан насосын систем суурилуулах ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан “Нар Энержи селикон метал” ХХК гэрээний үүргээ биелүүлээгүйгээс тус ажил 56.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төслийн удирдах хорооны 2024 оны 4 дүгээр тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийт 64,936,490.0 мянган төгрөгөөр баталж, 2025 оны 1 дүгээр тогтоолоор 70,334,740.8 мянган төгрөг болгон нэмэгдүүлэн баталсан байна.

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/36 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороо байгуулж, 2025 оны 8 дугаар сарын 13-ны өдөр тендер нээн, үнэлгээний тайланг АХБ-д хүргүүлсэн буюу ирүүлсэн санал дээр ажиллаж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэх нэгж түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг сайжруулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн ахлах аудитор Л.Номин, аудиторын туслах С.Булганчимэг, Б.Хонгорзул нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Болормаа, компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Үндэсний аудитын газрын ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсөл хэрэгжүүлэх нэгжээс Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,159,198.8 мянган төгрөгийн 1.5 хувь буюу 17,388.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэх нэгжийн албан хэрэгцээнд албан тушаалын суудлын автомашин ашиглаагүй, баталсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 351,937.0 мянган төгрөгийн 9 гүйлгээ байршуулахаас зарлагын 81,378.4 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр тухай бүр мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Завхан аймгийн Улиастай хотын Жавхлант цогцолбор сургуулийн өргөтгөлийн барилгын дулаан хангамжийн 110 кВт-ын хүчин чадалтай хөрсний дулааны насосын системийн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хангаагүйгээс комиссын акт баталгаажуагүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулан шат шатны арга хэмжээ авсан боловч бүрэн хэрэгжээгүй байна. Тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн удирдлагаас тухайн ажлыг гүйцэтгэгч “Нар Энержи селикон метал” ХХК-ийн удирдлагад ажлаа хугацаандаа гүйцэтгэх талаар төслийн нэгжээс удаа дараа албан бичиг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1		1		60.0
Нийт дүн	1		1		60.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх зорилгоор төслийн инженер техникийн ажилтан, албан хаагчид орон нутагт албан томилолтоор ажиллахдаа гаднын байгууллагатай хийсэн гэрээгээр тайлант онд автомашины түрээсийн төлбөрт 25,650.0 мянган төгрөгийг, жолоочийн томилолтын зардалд 14,290.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.
- Эрчим хүчний яамны захиалгаар төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгуудын сумдын дөрвөн байршилд хөрсний гүнийн дулааны насос суурилуулах түлхүүр гардуулах нөхцөлтэй олон улсын нээлттэй тендер шалгаруулалтад “Нар Энержи селикон метал” ХХК, ОХУ-ын Броск ХХК-ийн түншлэл шалгарч 2021-2023 онд гэрээ байгуулан ажилласан боловч гэрээний үүргийн биелэлт

одоо болтол хангалтгүй байгаа тул Эрчим хүчний яаманд зарласан худалдан авах ажиллагааны тендерийн шалгаруулалтыг Эрчим хүчний яамны хөрөнгө оруулалтын аудитаар анхаарч, гэрээгээр ажил гүйцэтгэгч түншлэл байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит оруулах саналтай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,096,040.3 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөлтийн эх үүсвэрийг 773,491.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн эх үүсвэрийг 264,293.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Албан томилолтын урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоо дансаар дамжуулалгүй 58,256.0 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 9.6-д “Урьдчилж төлсөн тооцоог дараах байдлаар бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 237,872.9 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд 237,872.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 237,872.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 17,388.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 220,484,9 мянган төгрөгөөр давсан тул тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Эрчим хүчний яамны захиалгаар төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгийн сумдын дөрвөн байршилд хөрсний гүнийн дулааны насос суурилуулах түлхүүр гардуулах нөхцөлтэй олон улсын нээлттэй тендер шалгаруулалтад “Нар Энержи селикон метал” ХХК, ОХУ-ын Броск ХХК-ийн түншлэл шалгарч 2021-2023 онд гэрээ байгуулсан боловч дээрх ажлуудын гэрээний хугацаа дууссан, төслийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 24.5 хувийн, барилга угсралтын ажлын гүйцэтгэл дунджаар 56.6 хувийн, санхүүжилт 62.3 хувийн гүйцэтгэлтэй, улсын комиссын дүгнэлт баталгаажаагүй байна. Тухайлбал:

- Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар сургуулийн барилгын дулаан хангамжид 110.0 кВт чадалтай дулааны насос, 25.0 кВт чадалтай нарны коллектор суурилуулах ажлын гүйцэтгэлийг 2023 онд ашиглалтад өгсөн боловч дулааны техник алдагдлын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тайлангаар суурилагдсан хүчин чадал нь нийт барилгыг халаахад хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан;

- Баянхонгор аймгийн Өлзийт сумын ахлах сургуулийн барилгын дулаан хангамжид 106.2 кВт суурилуулах ажлын хүрээнд Броск II -500 маркийн насосын оронд Хятад улсын CGS-52 маркийн 56.0 кВт-ын насос суурилуулсан, Эрчим хүчний яамнаас насос солих талаар албан ёсны зөвшөөрөл аваагүй;
- Говь-Алтай аймгийн Алтай сумын эмнэлэг, захиргааны барилгын дулаан хангамжид 95.0 кВт хөрсний гүний дулааны насосын систем суурилуулах ажлын хүрээнд батлагдсан ажлын зургийн дагуу 100 метрийн гүнтэй өрөмдөх ажлыг 30 метрийн 4 цооног болон бусад цооногийг 2-5 метрийн гүнтэй өрөмдөж ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, мөн 15,825.00 ам.доллар буюу 56,284.1 мянган төгрөгийн /2025.12.31-ны өдрийн Монгол банкны ханш 3,556.66/ үнэтэй 53.1 кВт хүчин чадалтай 1 ширхэг насосыг дутаасан талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн албан томилолтын ажлын тайланд тусгасан;
- Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар сургуулийн барилгын дулаан хангамжид 244.0 кВт хөрсний дулаан насосын систем суурилуулах ажлын хүрээнд 75.0 кВт чадалтай нарны коллектор суурилуулах байтал 36.0 кВт чадалтай коллектор суурилуулсан, зөрүүг тооцоогүй, мөн 51,056.00 ам.доллар буюу 181,588.8 мянган төгрөгийн /2025.12.31-ны өдрийн Монгол банкны ханш 3,556.66/ үнэтэй 81.5 кВт чадалтай 2 ширхэг насосыг дутаасан талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн албан томилолтын ажлын тайланд тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, Засгийн газрын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана”, Гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр бүлэг “Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага” хэсгийн 9.1-д “Гүйцэтгэгч нь гэрээний дагуу төлөвлөсөн ажлыг бүрэн хийж дуусгах” гэж заасныг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үлдэгдлийг баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх талаар арга

хэмжээ авч, гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тооллого хийсэн боловч хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа бодит үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдэл хоорондын зөрүүг тооцоолоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “Тооллогын комисс дараах үүрэгтэй”, 4.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, 73 дугаар зүйлийн 73.1-д “Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно”, 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа бодит үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдэл хоорондын зөрүүг тохируулан тооцож, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөлтийн эх үүсвэрийг 773,491.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн эх үүсвэрийг 264,293.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан байна.	1	1,037,784.3					1	1,037,784.3					
Албан томилолтын урьдчилгааг Урьдчилж төлсөн тооцоо дансаар дамжуулалгүй 58,256.0 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан байна.	1	58,256.0					1	58,256.0					
Дүн	2	1,096,040.3					2	1,096,040.3					

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчлийн товч утга												
Эрчим хүчний яамны захиалгаар, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр тус төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгуудын сумдын дөрвөн байршилд хөрсний гүнийн дулааны насос суурилуулах түлхүүр гардуулах нөхцөлтэй олон улсын нээлттэй тендер шалгаруулалтад "Нар Энержи селикон метал" ХХК, ОХУ-ын Броск ХХК-ийн түншлэл шалгарч 2021-2023 онуудад гэрээ байгуулсан боловч дээрх ажлуудын гэрээний хугацаа дууссан, төслийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 24.5 хувьтай, барилга угсралтын ажлын гүйцэтгэл дунджаар 56.6 хувьтай, санхүүжилт 62.3 хувийн гүйцэтгэлтэй, улсын комиссын дүгнэлт баталгаажгаагүй байна. Тухайлбал:	1	237,872.9			1	237,872.9						
-Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар сургуулийн барилгын дулаан хангамжид 110.0 кВт чадалтай дулааны насос, 25.0 кВт чадалтай нарны коллектор суурилуулах ажлын гүйцэтгэлийг 2023 онд ашиглалтад өгсөн боловч "дулааны техник алдагдлын тайлан"-гаар суурилагдсан хүчин чадал нь нийт барилгыг халаахад хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан байна. -Баянхонгор аймгийн Өлзийт сумын ахлах сургуулийн барилгын дулаан хангамжид 106.2 кВт суурилуулах ажлын хүрээнд Броск II -500 маркийн насосын оронд Хятад улсын CGS-52 маркийн 56.0 кВт-ын насос суурилуулсан,												

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>Эрчим хүчний яамнаас насос солих талаар албан ёсны зөвшөөрөл аваагүй байна. -Говь-Алтай аймгийн Алтай сумын эмнэлэг, захиргааны барилгын дулаан хангамжид 95.0 кВт хөрсний гүний дулааны насосын систем суурилуулах ажлын хүрээнд батлагдсан ажлын зургийн дагуу 100 метрийн гүнтэй өрөмдөх ажлыг 30 метрийн 4 цооног болон бусад цооногийг 2-5 метрийн гүнтэй өрөмдөж ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, мөн 15,825.00 ам.доллар буюу 56,284.1 мянган төгрөгийн /2025.12.31-ны өдрийн Монгол банкны ханш 3,556.66/ үнэтэй 53.1 кВт хүчин чадалтай 1 ширхэг насосыг дутаасан талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн албан томилолтын ажлын тайланд тусгасан байна. -Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар сургуулийн барилгын дулаан хангамжид 244.0 кВт хөрсний дулаан насосын систем суурилуулах ажлын хүрээнд 75.0 кВт чадалтай нарны коллектор суурилуулах байтал 36.0 кВт чадалтай коллектор суурилуулсан, зөрүүг тооцоогүй, мөн 51,056.00 ам.доллар буюу 181,588.8 мянган төгрөгийн /2025.12.31-ны өдрийн Монгол банкны ханш 3,556.66/ үнэтэй 81.5 кВт чадалтай 2 ширхэг насосыг дутаасан талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн албан томилолтын ажлын тайланд тусгасан байна.</p>															<p>1</p>
<p>Дүн</p>	<p>2</p>	<p>237,872.9</p>	<p>1</p>	<p>237,872.9</p>	<p>1</p>	<p>237,872.9</p>	<p>1</p>	<p>237,872.9</p>	<p>1</p>	<p>237,872.9</p>	<p>1</p>	<p>237,872.9</p>	<p>1</p>	<p>237,872.9</p>	<p>1</p>

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 81,378.4 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	81,378.4					1	81,378.4
Дүн	1	81,378.4					1	81,378.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1184/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/45/НА - СТА - ТХМ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний яамны захиалгаар төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгийн сумдын дөрвөн байршилд хөрсний гүнийн дулааны насос суурилуулах түлхүүр гардуулах нөхцөлтэй олон улсын нээлттэй тендер шалгаруулалтад Нар Энержи селикон метал ХХК, ОХУ-ын Броск ХХК-ийн түншлэл шалгарч 2021-2023 онд гэрээ байгуулсан боловч дээрх гэрээний хугацаа дууссан, төслийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 24.5 хувь, барилга угсралтын ажлын гүйцэтгэл дунджаар 56.6 хувь, санхүүжилт 62.3 хувийн гүйцэтгэлтэй, улсын комиссын дүгнэлт баталгаажуулаагүй байна. Тухайлбал:

1. Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар сургуулийн барилгын дулаан хангамжид 110.0 кВт чадалтай дулааны насос, 25.0 кВт чадалтай нарны коллектор суурилуулах ажлын гүйцэтгэлийг 2023 онд ашиглалтад өгсөн боловч дулааны техник алдагдлын тайлангаар суурилагдсан хүчин чадал нь нийт барилгыг халаахад хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан.
2. Баянхонгор аймгийн Өлзийт сумын ахлах сургуулийн барилгын дулаан хангамжид 106.2 кВт суурилуулах ажлын хүрээнд Броск II -500 маркийн насосын оронд Хятад улсын CGS-52 маркийн 56.0 кВт-ын насос суурилуулсан, Эрчим хүчний яамнаас насос солих талаар албан ёсны зөвшөөрөл аваагүй.
3. Говь-Алтай аймгийн Алтай сумын эмнэлэг, захиргааны барилгын дулаан хангамжид 95.0 кВт хөрсний гүний дулааны насосын систем суурилуулах ажлын хүрээнд батлагдсан ажлын зургийн дагуу 100 метрийн гүнтэй өрөмдөх ажлыг 30 метрийн 4 цооног болон бусад цооногийг 2-5 метрийн гүнтэй өрөмдөж ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, мөн 15,825.00 ам.доллар буюу 56,284.1 мянган төгрөгийн /2025.12.31-ний өдрийн Монгол банкны ханш 3,556.66/ үнэтэй 53.1 кВт хүчин чадалтай 1 ширхэг насосыг дутаасан талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн албан томилолтын ажлын тайланд тусгасан байна.
4. Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар сургуулийн барилгын дулаан хангамжид 244.0 кВт хөрсний дулаан насосын систем суурилуулах ажлын хүрээнд 75.0 кВт чадалтай нарны коллектор суурилуулах байтал 36.0 кВт чадалтай коллектор суурилуулсан, зөрүүг тооцоогүй, мөн 51,056.00 ам.доллар буюу 181,588.8 мянган төгрөгийн /2025.12.31-ны өдрийн Монгол банкны ханш 3,556.66/ үнэтэй 81.5 кВт чадалтай 2 ширхэг насосыг дутаасан талаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженерийн албан томилолтын ажлын тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-51.Docx

1526181901

зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, Засгийн газрын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана”, Гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр бүлэг “Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага” хэсгийн 9.1-д “Гүйцэтгэгч нь гэрээний дагуу төлөвлөсөн ажлыг бүрэн хийж дуусгах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үлдэгдлийг баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч, гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх; .,
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний салбарын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч Н.Ууганчимэг, санхүүгийн мэргэжилтэн Г.Золзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДОЛГОРСҮРЭН

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:
БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.ЖИГДЭН

